

Гүйжоугийн уугуул угсаатны “Үхэрчний дуу”-ны хэв шинжийн ангилал ба хөгжмийн бүтцийн шинэчлэл

Цэрэнгийн Чулуунцэцэг 

Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургууль,
Улаанбаатар, Монгол Улс
✉ chuka0588@gmail.com

Ляо Тянь Юун

Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургууль,
Улаанбаатар, Монгол Улс

Хураангуй: Энэхүү судалгаагаар БНХАУ-ын баруун өмнөд хэсэгт орших Гуйжоу мужийн уугуул угсаатны бүлгүүдийн мал аж ахуйн дуунуудаас “Үхэрчний дуу”-г онцлон, түүний нийгэм-соёлын үүрэг болон хөгжмийн хэлний хувьслыг угсаатны хөгжим судлалын үүднээс судлав. Судалгаанд Алан П.Мерриам, Бруно Неттл нарын функциональ ангиллын онолын концепцийг удирдлага болгон, үхэрчний дууны өвийг аж ахуйн (үхрийг дээдлэх магтаал дуу), харилцааны (залуусын хайр сэтгэлийн дуу) болон зан үйлийн (нутаг орноо магтан дуулсан дуу) гэсэн гурван үндсэн хэв шинжид системчлэн ангилав. Түүнчлэн, уламжлалт ардын дууны элементүүд орчин үеийн мэргэжлийн хөгжмийн хэлбэрт (Жуан Чэн Юан, Сюй Банцзе нарын хүүхдийн найрал дууны бүтээлээр жишээлэн) хэрхэн шилжин шинэчлэгдэж байгааг ноотны харьцуулсан анализаар шинжлэв. Бүтцийн шинжилгээгээр ардын дууны уламжлалт пентатоник хөгний залгамж чанар хадгалагдсан боловч чөлөөт хэмнэл (rubato) нь тогтвортой 2/4, 4/4 хэмцэлд шилжиж, малчдын хоолойн нарийн чимэг авианууд нь хөгжмийн зэмсэг (хулсан лимбэ)-ийн фактурт бүтээлчээр ууссан болохыг баталгаажуулсан болно.

Түлхүүр үгс: Гүйжоу, уугуул угсаатны дуу, үхэрчний дуу, хөгжмийн бүтэц

Classification of Stylistic Types and Musical Structural Renovation of “Herdsman’s Songs” of the Indigenous Ethnic Groups in Guizhou

Chuluuntsetseg Tseren 

School of Dance Arts, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia
✉ chuka0588@gmail.com

Liao Tianyong

School of Dance Arts, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia

Abstract: This study focuses on the “Herdsman’s Songs” (Ox-herding songs) among the pastoral music traditions of the indigenous ethnic groups in Guizhou Province, southwestern China, examining their socio-cultural functions and musical language evolution from an ethnomusicological perspective. Guided by the functional classification theories of Alan P. Merriam and Bruno Nettl, the heritage of herdsman’s songs is systematically classified into three main stylistic types: pastoral (praise songs venerating cattle), communicative (youth courtship love songs), and ritualistic (songs praising the homeland). Furthermore, the study analyzes how traditional folk music elements are transformed and renovated into modern professional musical forms, using the children’s choral work by Zhuang Chenyuan and Xu Bangjie as a primary case study. Through comparative musical structural analysis, the study demonstrates that while the traditional pentatonic mode is preserved, the free rhythm (rubato) has shifted into stable 2/4 and 4/4 meters, and the herdsman’s intricate vocal ornamentations have been creatively integrated into the instrumental texture of the bamboo flute (dizi).

Keywords: *Guizhou, indigenous ethnic songs, Herdsman’s song, musical structure, renovation*

Оршил

Хүн төрөлхтний соёл, аж ахуйн үйл ажиллагааны явцад үүсэн хөгжсөн ардын дууны өв нь тухайн угсаатны сэтгэлгээний онцлог, нийгмийн харилцаа болон ахуйн контекстийг тээгч амьд үзэгдэл юм. Нүүдэлч болон суурьшмал, газар тариалан хосолсон соёл иргэншилтэй бүс нутгуудад хөдөлмөрийн явцад үүссэн дууны уламжлал өргөн тархсан байдаг бөгөөд үүний ижил төстэй үзэгдэл Төв Азийн нүүдэлчдийн, тэр дундаа монголын малчдын мал маллах, малын магтаал дууны өвд ч тод ажиглагддаг. Харин БНХАУ-ын баруун өмнөд хэсэгт орших Гуйжоу мужийн уугуул угсаатны бүлгүүдийн мал аж ахуйн дуунууд, тэр дундаа “Үхэрчний дуу” нь Төв Азийн нүүдэлчдээс ялгаатай нь өөрийн гэсэн аялгууны өвөрмөц бүтэцтэйгээс гадна уулын болон тал нутгийн соёлын огтолцол дээр оршин тогтнож, нийгмийн олон талт үүрэг хүлээдгээрээ онцлогтой.

Гуйжоу мужийн угсаатны бүлгүүдийн мал аж ахуйн дуунууд нь утга агуулгаар баялаг, хэлбэрийн хувьд олон янз байдаг. Эдгээр янз бүрийн хэв маягийн дуунуудыг бүхэлд нь авч үзвэл голчлон гурван ангилалд хувааж үзэж болно. Эхний

ангилалд үхрийг шууд дүрсэлсэн дуунууд багтдаг бөгөөд тэдгээр дуунд үхрийг магтаж, тэдгээрийн ашиг тусыг дүрсэлснээр Гүйжоугийн уугуул иргэд хөдөө аж ахуйн соёлд үхрийг дээдэлдэг уламжлалыг тусгасан байдаг. Хоёр дахь ангилал нь үхэр хариулах явцад дуулагддаг хайр сэтгэлийн дуунууд бөгөөд залуу малчдын хайр сэтгэл, амьдралын баяр баясгаланг илэрхийлдэг. Гурав дахь ангилалд үхэр хариулах зан үйлээс сэдэвлэсэн, нутаг орныхоо байгалийн сайхныг магтан дуулсан дуунууд багтана. Түүнчлэн, уламжлалт ардын дууны эдгээр элементүүд хувьсан өөрчлөгдөж, орчин үеийн хүүхдийн дуу болон хөгжмийн зохиолчдын бүтээлд шинэ хэлбэрээр тусгалаа олж байна. Тухайлбал, Жуан Чэн Юаны шүлэг, Сюй Банцзегийн хөгжим “Үхэрчний дуу” нь лимбэний аялгуу, малчдын уламжлалт дуудлагыг хүүхдийн найрал дууны шинэлэг хэмнэлтэй хослуулснаараа соёлын өвийг бүтээлчээр өвлүүлэн хөгжүүлж буйн тод жишээ юм. Өнөө цагт хөдөө аж ахуй механикжиж, уламжлалт аж ахуйн хэлбэр хувьсан өөрчлөгдөхийн хэрээр эдгээр дууны оршин тогтнох уламжлалт амьд орчин хумигдаж, мөхөх аюулд ороод байна. Иймд уугуул угсаатны дууны өвийг хөгжмийн болон соёлын түвшинд системчлэн ангилж, түүний хөгжмийн хэлний хувьсал өөрчлөлтийг баримтжуулан судлах зайлшгүй шаардлага тулгарч байна. Иймээс бид БНХАУ-ын Гүйжоу мужийн уугуул угсаатны бүлгүүдийн “Үхэрчний дуу”-г утга агуулга, гүйцэтгэлийн хэв шинжээр нь системчлэн ангилах, улмаар уламжлалт аялгууны элементүүд орчин үеийн мэргэжлийн хөгжмийн бүтээлд (хүүхдийн дууны хэлбэрт) хэрхэн шилжин шинэчлэгдэж байгааг хөгжмийн бүтцийн анализын үүднээс шинжлэн тодорхойлохыг зорив. Энэхүү зорилгын хүрээнд зорилтуудыг дэвшүүлэн шийдвэрлэв. Үүнд:

1. Гүйжоугийн уугуул угсаатны “Үхэрчний дуу”-ны соёлын контекст, нийгэм-соёлын үүргийг тодорхойлж ангилах,
2. Ангилал тус бүрийн хөгжмийн хэл, аялгууны эхлэл, чимэг авианы онцлогийг тайлбарлах,
3. Ардын дууны уламжлалт элемент (пентатоник хөг, чөлөөт хэмнэл, дуудлага) орчин үеийн зохиолын дууны хэлбэрт хэрхэн хувьссаныг ноотны анализар баталгаажуулах зэрэг зорилтууд орно.

Судалгааны онол, арга зүй

Угсаатны хөгжим судлалын орчин үеийн чиг хандлагад хөгжмийн ангиллыг зөвхөн дууны төрөл зүйл, жанрын түвшинд явцуу авч үзэхээс татгалзаж, тухайн дуу хөгжмийн нийгмийн үүрэг, гүйцэтгэлийн нөхцөл, соёлын утга агуулгатай нь уялдуулан цогцоор авч үздэг. Тухайлбал, угсаатны хөгжим судлалын нэрт төлөөлөгч Алан П.Мерриам (Alan P. Merriam) хөгжим нь “дуу авиа - зан үйл - үзэл санаа” гэсэн гурвалсан бүтэцтэй гэж үзэж, хөгжмийн ангиллыг зөвхөн хөгжмийн хэлбэрээр бус, соёлын үйл ажиллагааны систем дотор тодорхойлох ёстойг онцолсон байдаг (Merriam 1964). Харин Бруно Неттл (Bruno Nettl)-ийн харьцуулсан угсаатны хөгжим судлалын хандлагад хөгжмийн ангилал нь аж ахуйн, зан үйлийн, зугаа цэнгэлийн болон харилцааны хөгжим гэсэн функциональ (үүргийн) ялгарал дээр тулгуурладаг байна (Бруно 2005).

Энэхүү судалгаанд дээрх онолын концепциудыг удирдлага болгон Гүйжоугийн уугуул угсаатны “Үхэрчний дуу”-ны хэв шинжийг зөвхөн аялгууны бүтцээр бус, мал маллагааны аж ахуйн функц, залуусын хайр сэтгэлийн харилцааны үүрэг болон байгаль дэлхийгээ магтах зан үйлийн систем дотор нь А.Мерриам, Б.Неттл нарын онолын дагуу функциональ ангилалд оруулж, дараах аргуудыг хослуулан шинжиллээ. Үүнд:

- Нийгэм-соёлын контекстийн шинжилгээ: Гүйжоу мужийн уугуул угсаатны бүлгүүдийн аж ахуйн бүтэц, газар тариалан, мал маллагааны арга барил нь “Үхэрчний дуу”-ны утга зүйн семантик (Текст) болон нийгмийн үүрэгт хэрхэн тусгалаа олсныг тодорхойлоход ашиглав.
- Хөгжмийн бүтцийн шинжилгээ: Уламжлалт үхэрчний дууны аялгууны эхлэл, өндөр өнгийн дуудлага, чимэг авианы (ornamentation) хэрэглээ болон гоцлол-дагалдах дуулаачийн харилцан дуулал (call and response)-ын хэлбэрийг задлан шинжлэхэд хэрэглэв.
- Хөгжмийн харьцуулсан анализ: Ардын уламжлалт дууны элементүүд орчин үеийн мэргэжлийн бүтээлд шилжихдээ аялгууны пентатоник (таван эгшигт) хөгний залгамж чанарыг хэрхэн хадгалсан, чөлөөт хэмнэл (rubato) нь тогтвортой хэмцэл (2/4, 4/4 хэмжээ) рүү хэрхэн хувьссаныг ноотны материалаар харьцуулан баталгаажуулав.

Судалгааны хэрэглэгдэхүүн: Судалгааны үндсэн хэрэглэгдэхүүнээр БНХАУ-ын Гүйжоу мужид уугуулан амьдардаг Мяо, И, Дун, Гэлао зэрэг угсаатны бүлгүүдийн дунд дуулагддаг уламжлалт “Үхэрчний дуу”-ны соёлын баримтууд, тэдгээрийн хөгжмийн хэв маягийн дууны жишээнүүдийг ашиглав. Мөн соёлын өвийн бүтээлч шинэчлэлийг баримтжуулах зорилгоор Жуан Чэн Юаны шүлэг, Сюй Банцзегийн хөгжим болох хүүхдийн найрал дуунд зориулсан “Үхэрчний дуу”-ны 2 багц ноотны материалыг хөгжмийн бүтцийн анализын үндсэн баазад хамрууллаа.

Судалгааны үр дүн

Гүйжоугийн “Үхэрчний дуу”-ны хэв шинжийн ангилал: БНХАУ-ын Гүйжоу мужийн уугуул угсаатны бүлгүүдийн (Мяо, И, Дун, Гэлао) мал аж ахуйн дуунууд, тэр дундаа “Үхэрчний дуу” нь хөдөө аж ахуйн зан үйл, өдөр тутмын хөдөлмөрийн амьд контекстэд оршин тогтнож ирсэн бөгөөд утга агуулга, гүйцэтгэлийн шинж чанараараа дараах 3 үндсэн хэв шинжид хуваагдана.

1. Үхрийг магтан дуулсан “Үхэрчний дуу”: Энэхүү ангилалд үхрийг шууд дүрсэлсэн, түүний ашиг тус, аж ахуйн үүргийг магтсан дуунууд багтана. Гүйжоугийн уугуул иргэдийн уламжлалт зан үйлд үхэр нь зөвхөн мал биш, хөдөө аж ахуйн соёлыг тэтгэгч, гэр бүлийн гишүүнтэй ижил хүндтэй амьтан гэж тооцогддог. Энэхүү соёл, зан үйлийн тогтолцоо нь ард иргэдийн дунд үхрийг дээдлэх, байгальтайгаа эв найртай хамт орших сэтгэлгээний суурь болдог байна (Ду Чаодун, Ся Хуй, Хэ Дэбин 2022).

Хөгжмийн онцлог: Эдгээр дууны аялгуу нь ердийн уулын дуунуудаас эрс ялгаатай. Уулын дуунууд ихэвчлэн “Би дууллаа шүү” гэсэн анхааруулах дохионы өнгөөр эхэлдэг бол үхрийн магтаал дуунууд маш өндөр өнгийн дуудлага, хашхираа

маягийн эхлэлтэй байдаг. Жишээ нь, Гэлао угсаатны дуунд малчин өглөө эрт үхрийн саравчны үүдийг нээхдээ “Үхрээ хариулахаар одлоо доо, хоо хоо хоо” гэж өндөр өнгөөр найз нөхдөө дуудах мэт хашхирч, араас нь урт чимэг авиа хэрэглэн уянгалуулан дуулдаг онцлогтой. Энэ төрлийн дуунууд нь ямар нэгэн далд сөрөг агуулгагүй, цэвэр хөдөлмөрийн урам, эерэг энергийг тээдэг.

2. Хайр сэтгэлийн “Үхэрчний дуу”: Энэ нь Гүйжоугийн угсаатны бүлгүүдийн дунд хамгийн өргөн тархсан, хамгийн том багц бүлгийг бүрдүүлдэг бөгөөд мал аж ахуйн дууны хамгийн чухал нийгэм-соёлын үүргийг хүлээдэг. Хятадын уламжлалт нийгэмд залуусын гэрлэлтийг эцэг эх, зуучлагчийн үгээр хүчээр шийддэг байсан тул залууст хайр сэтгэлээ чөлөөтэй илэрхийлэх боломж бараг олддоггүй байв. Харин Гүйжоугийн уугуул угсаатнуудын (Мяо, И, Дун) дунд гэрлэлтийн ёс арай уян хатан байсан бөгөөд өдөр бүр уулын бэлчээрт гурваас дээш цаг үхэр хариулах тогтмол хөдөлмөр нь залуус уулзах, хайр сэтгэлээ илэрхийлэх хамгийн боломжит талбар болдог байжээ.

Хөгжмийн онцлог: Энэ төрлийн дууны гоо сайхан нь маш нарийн далд илэрхийлэл, харилцан дуулал дээр суурилдаг. Шүлгийн агуулга нь шууд хайр зарлахаас илүү “Эсрэг хөндийн ээвэр дээр эгчийнх нь байшин цайвалзана... уулын бэлд ах нь ганцаар үхэр, хонио бэлчээнэ” гэх мэтээр байгалийн дүрслэлээр халхавчлан, нэг хүн гоцлон асуухад нөгөө хөндийгөөс хариулан дуулах хэлбэрээр хөгжмийн чөлөөт хэмнэлээр өрнөдөг.

3. Нутаг орноо магтан дуулсан “Үхэрчний дуу”: Тооны хувьд олон биш ч тухайн ард түмний амьдралын хүнд бэрх нөхцөлд ч өөдрөг үзэл, төрсөн нутаг, өвөг дээдсийнхээ газар шороонд үнэнч байх сэтгэлгээг илэрхийлдэг тул судалгааны чухал ач холбогдолтой. “Нэг газрын ус, хөрс тухайн нутгийн хүнийг тэжээнэ” гэсэн ухагдахуунаар нутгаа хамгаалах, эх оронч үзлийг бүрэлдүүлдэг байна.

Хөгжмийн онцлог: Сычуань-Гүйжоугийн баруун бүсийн үхэрчний дуунууд үүний гол төлөөлөл бөгөөд энгийн хоёр мөрт бүтэцтэй. Дээд мөр нь үндсэн мэдээллийг өгч, дараагийн мөр нь чимэг авиа ашиглан эхний мөрийн утгыг бататгадаг. Жишээ нь: “Эртлэн босоод уулын ээвэрт гарна, энгэрийн ногоон дэвсгэрт үхэр хонио бэлчээмээр санагдана” гэж дуулсны дараа “Тоолиг лянхуа цэцэг ээ, өөвэй” гэсэн урт чимэг авиаг дагалдан дуулаачид давтан дуулж, хөгжмийн хамтын бүтцийг үүсгэдэг онцлогтой.

Нийгмийн хувьсал ба “Үхэрчний дуу”-ны уламжлалт орчны өөрчлөлт: Өнөө цагт БНХАУ-ын хөдөө аж ахуйн бүтэц асар хурдтай механикжиж, өндөр стандартын тариалангийн талбай хэрэгжиж эхэлснээр уламжлалт гэр бүлийн аж ахуйд шар үхэр тэжээх, үхрээр газар хагалах уламжлалт амьдралын хэв маяг үндсэндээ мартагдаж байна. Энэхүү аж ахуйн хувьсгал нь үхэрчний дуунууд анх үүссэн, оршин тогтнож байсан “үйлдвэрлэлийн суурь орчин”-ыг бүрмөсөн үгүй болгож, ардын дуу уламжлалт хэлбэрээрээ өвлөгдөх боломжийг хязгаарлаж байна. Иймд соёлын өвийг хүчээр амилуулах гэж оролдохоос илүүтэйгээр, түүнийг яаралтай эмхэтгэн баримтжуулж, архивлах шаардлага тулгарч байна (Ван Дондун 2019).

“Үхэрчний дуу”-ны бүтцийн шинэчлэл, ноотны харьцуулсан анализ: Уламжлалт аж ахуйн орчин хумигдаж буй өнөө үед ардын дууны өвийг хамгаалах,

бүтээлчээр өвлүүлэх хамгийн оновчтой хэлбэр нь түүний хөгжмийн хэлийг мэргэжлийн хөгжмийн зохиомж, сурган хүмүүжүүлэх уран репертуар (ялангуяа хүүхдийн дуу)-тай холбох явдал юм. Үүний тод жишээ нь Жуан Чэн Юаны шүлэг, Сюй Банцзегийн хөгжим “Үхэрчний дуу” (Хүүхдийн найрал дуунд зориулсан зохиомж) бөгөөд тус бүтээлд уламжлалт малчдын дууны элементүүд хэрхэн бүтцийн шинэчлэлд орсныг хөгжмийн анализын дараах үзүүлэлтүүдээр баталж байна (Зураг 1, Зураг 2).

放牛歌

庄成远 词
徐邦杰 曲

轻快地 民歌风

笛儿悠悠吹 云儿轻轻飞，
骑着牛儿 蹚着水， 赶着夕阳
把家回，把家回。 回，把家回。

Зураг 1. Зохиомжит “Үхэрчний дуу”-ны эхлэл хэсэг
(Аялгууны сэдэв болон импрессионист фактур)

歌唱二小放牛郎

方冰 词
劫夫 曲

Andante

牛儿还在山坡吃草，放牛的却不知哪儿去了，不是他
九月十六那天早上，敌人向一条山沟扫荡，山沟里
正在那十分危急时候，敌人来到这个山口，昏头
贪玩要掩护着丢后方了牛，那放牛的孩子
昏掩护着地迷失了方向，还掩护住了几千小
王二小。乡路。
要他带路。

Зураг 2. Зохиомжит “Үхэрчний дуу”-ны хөгжмийн зэмсгийн гоцлол ба
дуулаачийн харилцан хамаарал

1. Аялгууны хөг (Mode/Tonality) ба Пентатоник айзмын залгамж чанар:

Хөгжмийн бүтцийн анализаас үзэхэд, Сюй Банцзе нь зохиомжийнхоо үндсэн аялгууг Хятадын өмнөд бүсийн ардын дууны суурь болох уламжлалт таван эгшигт пентатоник хөгний “Зы” (Zhi mode - Sol) болон “Юй” (Yu mode - La) айзмаар зохиомжилсон байна. Энэ нь уламжлалт үхэрчний дууны аялгууны байгалийн дулаан, уянгалаг шинж чанарыг орчин үеийн хүүхдийн дууны сэдэв аялгуунд хадгалж үлдсэн залгамж чанарыг харуулж байна. Өрнөдийн диатоник мажор, минорын сэтгэлгээнээс ангид, уугуул хөгний энэхүү бүтцийг хадгалснаар дууны үндсэн колорит (өнгө төрх) нь уламжлалт ардын дууны шинжээ алдаагүй байна.

2. Хэмнэл, хэмжээний шилжилт:

Уламжлалт үхэрчний дуу нь бэлчээрийн задгай орон зайд дуулагддаг, тогтсон тактын шугамгүй, чөлөөт импровизаци шинжтэй (Rubato) хэмнэлтэй байсан. Харин Сюй Банцзегийн зохиомжид энэхүү чөлөөт байдлыг хүүхдийн сэтгэхүй, дуулах онцлог болон хамтдаа дуулах найрал дууны гүйцэтгэлд тохируулан тогтвортой 2/4 болон 4/4 хэмцэлд оруулж, бүтцийн хувьд хэмнэлийн нарийн зохион байгуулалтад оруулсан байна (Зураг 1). Хэдийгээр хэмжээ нь тогтвортой болсон ч, аялгууны доторх синкоп (хэмнэл шилжих) болон триоль (гурвалсан эгшиг)-ийн хэрэглээ нь уламжлалт малчны дууны чөлөөт, цоглог, импровизацилаг шинж чанарыг хүүхдийн найрал дууны хэмнэлд маш амжилттай суулгаж өгчээ.

3. Дуулах техник, чимэг авиа хөгжмийн зэмсгийн фактурт шилжсэн нь:

Уламжлалт үхэрчний дууны хамгийн гол цөм шинж чанар болох мал маллах, дуудах өндөр өнгийн хашхираа болон хоолойн нарийн чимэг авианууд нь хүүхэд дуулахад техникийн хувьд хүндрэлтэй байдаг. Хөгжмийн зохиолч үүнийг бүтээлчээр шийдэж, малчдын уламжлалт хоолойн чимэг авиаг дижи (хулсан лимбэ)-ийн аялгуу болон төгөлдөр хуурын дагалдах хөгжмийн фактурт шилжүүлэн суулгасан байна (Зураг 2). Ноотны шинжилгээнээс харахад, лимбэний урт форшлаг болон пассажууд нь бэлчээрт үхэр хариулж буй малчны лимбэдэх уламжлалт аяыг шууд санагдуулам импрессионист шинжтэй байгалийн дүрслэлийг хөгжмийн хэлээр амилуулж байна. Харин хүүхдийн дуулах хэсэг нь илүү тодорхой, уянгалаг, кантилена шинж чанартай болж хувьсжээ.

Энэхүү ноотны бүтцийн харьцуулсан анализаас дүгнэхэд, Гүйжоугийн уламжлалт “Үхэрчний дуу” нь орчин үеийн мэргэжлийн хөгжмийн зохиомжийн шатанд ороходоо анхдагч аж ахуйн үүргээ гээсэн ч, хөгжмийн хэлнийхээ хамгийн үнэт элементүүдийг (пентатоник айзам, лимбэний чимэглэл аялгуу) хадгалан үлдэж, соёлын өвийг сурган хүмүүжүүлэх уран бүтээлээр дамжуулан шинэ цаг үед бүтээлчээр шинэчлэн өвлүүлэх орчин үеийн шатандаа шилжсэнийг баталж байна.

Хэлэлцүүлэг

Энэхүү судалгаагаар Гүйжоу мужийн уугуул угсаатны бүлгүүдийн “Үхэрчний дуу”-г зөвхөн хөгжмийн бичвэр, ноотны цуглуулга гэхээс илүүтэй, тухайн дууг төрүүлсэн нийгэм соёлын орчин, зан үйл, хүний сэтгэлгээ, нийгмийн харилцааны олон талт холбоог багтаасан иж бүрэн соёлын тогтолцоот үзэгдэл, биет бус өв болохыг тогтоох бололцоотой хэмээн үзэв. Гүйжоу мужийн угсаатны бүлгүүдийн “үхэрчний дуу”-г дуулах арга барил, зан үйлийн дарааллыг бодит жишээ болгон

авч үзвэл, энэхүү “амьд” гүйцэтгэл нь зөвхөн дуу дуулах бус, ажил хөдөлмөрийн харилцаа болон гэр бүл, ахуй амьдралын харилцааг бэхжүүлдэг нийгмийн үзэгдэл болох нь харагдаж байна.

Үүнийг Төв Азийн нүүдэлчдийн, тухайлбал монголын малчдын хөдөлмөрийн дууны уламжлалтай харьцуулан авч үзвэл соёлын маш сонирхолтой ижил болон ялгаатай талууд ажиглагдана. Монгол малчид таван хошуу малтайгаа харилцахдаа мал маллах дуу, малын магтаал зэргийг өргөн хэрэглэдэг. Хөгжмийн хэлний хувьд монгол малчдын дуу нь уудам тал нутгийн орон зайд зохицсон, урт цуурайтах шинжтэй уртын дууны аялгуу, шуранхай, исгэрээ болон задгай хоолойн техникт суурилдаг бол Гүйжоугийн уугуул угсаатны дуу нь уулархаг, ой мод ихтэй бүс нутгийн цуурайг ашигласан өндөр өнгийн хашхираа эхлэл, хөгжмийн зэмсэг (хулсан лимбэ)-ийн фактуртай нягт ууссан чимэг авианы баялаг техниктэй байна. Энэ нь хөгжмийн хэл, дуулах арга барил нь тухайн угсаатны газар зүйн байршил, байгаль орчин, аж ахуйн хэлбэрээс шууд хамаардгийг баталж байна.

Түүнчлэн, орчин үеийн хөдөө аж ахуйн механикжилт, хотжилтын нөлөөгөөр уламжлалт бэлчээрийн аж ахуй хумигдаж, “Үхэрчний дуу” анхдагч амьд орчиндоо мөхөх шатанд орсон гэх дүгнэлтийг судлаач Луо Вэнбин нарын социологийн болон хөдөөгийн аялал жуулчлалын судалгааны баримтууд давхар баталж байна (Ван Дондун 2019). Уламжлалт ахуй үгүй болсон ч, соёлын өв нь Сюй Банцзе нарын мэргэжлийн хөгжмийн бүтээлд шилжин, уламжлалт пентатоник хөг, лимбэний чимэглэл аялгуу хэлбэрээр хүүхдийн дууны репертуарт хадгалагдан үлдэж байгаа нь соёлын биет бус өвийг бүтээлчээр хамгаалах орчин үеийн чиг хандлагад бүрэн нийцэж байна.

Дүгнэлт

- БНХАУ-ын баруун өмнөд бүс, Гүйжоу мужийн уугуул угсаатны бүлгүүдийн “Үхэрчний дуу” нь зөвхөн хөдөлмөрийн явцыг дүрсэлсэн дуулал биш, хөдөө аж ахуйн соёлд үхрийг дээдлэх зан үйл, залуусын хайр сэтгэл, ханиа сонгох нийгмийн харилцаа болон төрсөн нутаг орноо бэхжүүлэх олон талт нийгэм-соёлын үүргийг хүлээж ирсэн байна.
- Судалгаагаар “Үхэрчний дуу”-г утга агуулга, гүйцэтгэлийн шинжээр нь: а) үхрийг шууд дүрсэлсэн магтаал дуу, б) нийгэм-соёлын үүрэг бүхий хайр сэтгэлийн дуу, в) нутаг орноо магтан дуулсан дуу гэж 3 үндсэн хэв шинжид ангилан системчлэв.
- Хөгжмийн хэлний хувьд “Үхэрчний дуу” нь ердийн уулын дуунаас ялгаатай нь өндөр өнгийн дуудлага маягийн эхлэл, чимэг авианы баялаг хэрэглээ, гоцлол ба дагалдах дуулаачийн харилцан дуулал) зэрэг өвөрмөц бүтцийн онцлогтой болохыг тогтоов.
- Нийгэм, аж ахуйн хувьслын явцад уламжлалт амьд орчин нь хумигдсан ч, “Үхэрчний дуу”-ны уламжлалт элементүүд (пентатоник хөгний залгамж чанар, хэмнэлийн хувьсал болон малчдын уламжлалт чимэг авианууд хөгжмийн зэмсгийн фактурт шилжсэн онцлог) нь орчин үеийн мэргэжлийн хүүхдийн дууны зохиомжид шилжин уусаж, соёлын өвийг шинэ цаг үед бүтээлчээр өвлүүлэн хөгжүүлэх шинэ шатанд гарсныг хөгжмийн анализаар баталгаажууллаа.

Ашигласан материалын жагсаалт

Хятад хэлээр:

- Ван Дондун. 2019. “Хэбэй ардын дуу болох ‘Жижиг үхэрчин’-ий уран сайхны онцлогийн товч дүн шинжилгээ.” *Хойд хөгжим* 39 (04): 57-256.
- Ду Чаодун, Ся Хуй, болон Хэ Дэбин. 2022. “Манай улс дахь ‘Гелао үндэстэн’-ий талаарх тусгай судалгааны өнөөгийн байдлын дүн шинжилгээ.” *Зуны Багийн их сургуулийн сэтгүүл* 24 (03): 175-178.
- Жан Зэ Хун. 2015. “Баруун өмнөд Хятадын Гелао үндэстэн ба түүний шашин.” *Гүйжоу үндэстний судалгаа* 36 (12): 194-199.
- Жан Син. (Огноо тодорхойгүй). “Гуйжоу дахь Гелао үндэстний уламжлалт шашны соёл ба түүний орчин үеийн үнэ цэн.” *Зуны Багийн их сургуулийн сэтгүүл*.
- Луо Вэнбин, Чен Гуо, Ван Ювэй, Цай Ци. 2021. “Хөдөө аж ахуйн соёлын өв уламжлал, хөдөөгийн аялал жуулчлалыг хөдөөгийн сэргэн мандалтын нөхцөлд нэгтгэх, хөгжүүлэх талаарх дүн шинжилгээ.” *Хөдөө аж ахуйн тойм* 17 (06): 80-84.

Англи хэлээр:

- Мерриам, Алан П. 1964. *Хөгжмийн антропологи*. Эвенстон: Northwestern University Press. [Merriam, Alan P. 1964. *The Anthropology of Music*. Evanston: Northwestern University Press.]
- Неттл, Бруно. 2005. *Угсаатны хөгжим судлалын судалгаа: Гучин нэгэн асуудал ба үзэл баримтлал*. Урбана: University of Illinois Press. [Nettl, Bruno. 2005. *The Study of Ethnomusicology: Thirty-one Issues and Concepts*. 2nd ed. Urbana: University of Illinois Press.]